

Их зохиолч Инжаннашийн бүтээл туурвилын гар бичмэлийг

Арлын орныг хүртэл мөшгихүйд

Суут эзэн Чингис хааны алтан ургийн тайж Ванчинбалын Инжаннаши /Билгэ билгийн Цогт гэсэн утга бүхий самгарди дуудлагатай үг, багын нэр нь Хасчулуу/ бол XIX зууны Монголын утга, соёлын нэрт зүтгэлтэн билээ.

“Дорнод Монголын утга зохиолын нийгэмлэг” гэдэг монгол утга зохиолыг эрхлэн хэвлэдэг хэвлэлийн газрыг утга, соёлын нэрт зүтгэлтэн Үүлингаагийн Бөххишиг тэргүүлэн үйл ажиллагаагаа явуулдаг байсан нь Өвөрмонголын Өөртөө засах орны хилийн боомтын жижиг хот болох Кайлу-д юм. Уг хэвлэлийн газрын сан хөмрөгт их зохиолч, В.Инжаннашийн хөхөлбөр ягаавтар өнгийн торгон баринтагтай, арван хоёр мянган хуудас бүхий арван хоёр боть судар хэвлэгдэж хадгалагдсан нь “Их Юань улсын мандсан төрийн Хөх судар” хэмээх түүх-уран сайхны туульсын зохиол байсан байна. В.Инжаннаши “Их Юань улсын мандсан төрийн Хөх судар” романаа 120 бүлгийг бичиж туурвисан гэх бөгөөд Мин, Чингийн үеийг хүртэлх буюу 1644 оны үйл явдлыг хүртэл бичсэн хэмээн эдүгээг хүртэл баруун түмэдийн, харчин монголчууд амнаас ам дамжин хэлж, ярьж, бичиж тэмдэглэсээр ирсэн юм. Ү.Бөххишиг, Шилэнгаа гэдэг хүнийг тусгайлан томилж Бэй Пио руу илгээн их зохиолч В.Инжаннашийн гар бичмэлүүдээс, баруудаас сурвалжлан цуглуулж хэвлэх, хадгалах, уламжлуулах зэрэг бүтээлч ажлыг хийжээ. 1943 онд тэрээр 42 настайдаа хорлогдсон бөгөөд өнөө хэр түүний үхлийн шалтгаан бүрхэг хэвээр байгаа билээ.

Миний бие, их зохиолчийн “Хөх судар” романы гар бичмэл, хувилбар эхүүд, бусад зохиолын нь гар бичмэлийг эрж хайх эрэл, хайгуулыг зогсолтгүй хийж байна. Хамгийн сүүлийн үеийн байдлаар /2019 оны намар, өвөл/ нэгэн шинэ эрлийг эхлүүлээд байна. Энэ эрэл хайгуулынхаа дагууд Япон Улсад хадгалагдаж байх бүрэн магадтай, их зохиолч Ванчинбалын Инжаннашийн зарим зохиол, бүтээлийн гар бичмэл, холбогдох материалуудыг энд дурдаж байна.